



193

БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН САЙДЫН ТУШААЛ

2021 оны 03 сарын 31 өдөр


Дугаар 74

Улаанбаатар хот

Барилга байгууламжийн 2021 оны үнийн индекс батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Барилгын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1.10 дахь заалт, Шинжлэх ухаан, техник технологийн зөвлөлийн хуралдааны 2021 оны 07 дугаар сарын 01-ний өдрийн 08/2021 дугаар шийдвэр, мөн зөвлөлийн хуралдааны 2021 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн 08/2021 дугаар шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Барилга байгууламжийн 2021 оны үнийн индекс”-ийг хавсралтаар баталсугай.
2. Энэхүү индексийг барилга байгууламжийн төсөвт өртгийг урьдчилан тодорхойлох, төлөвлөх, хөрөнгө оруулалтын үр ашгийг тооцох, төсөл хөтөлбөрийн тооцоо, судалгаа хийх, техник, эдийн засгийн үндэслэл боловсруулах, барилга угсралтын ажлын үнийн өөрчлөлтийн нөлөөллийг тооцох зэрэгт хэрэглэхээр тогтоосугай.
3. Барилга байгууламжийн төсөвт өртөгт дахин магадлал хийх, мөн магадлалаар баталгаажсан төсвийн хөрөнгө оруулалтын аливаа үйл ажиллагаанд “Барилга байгууламжийн 2021 оны үнийн индекс”-ийг хэрэглэхгүй байхыг “Барилгын хөгжлийн төв” ТӨААТҮГ /Ц.Амарсанаа/-т үүрэг даалгасугай.
4. Батлагдсан индексийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Барилга, барилгын материалын үйлдвэрлэлийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар /Д.Гантулга/-т, салбарын хэвлэл мэдээлэл, олон нийтийн хэрэгслээр нийтэд мэдээлэх ажлыг зохион байгуулахыг “Барилгын хөгжлийн төв” ТӨААТҮГ /Ц.Амарсанаа/-т тус тус үүрэг болгосугай.
5. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж, нэгдсэн удирдлагаар хангаж ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга /С.Магнайсүрэн/-д даалгасугай.



152210215